

**БУЛГАН АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД,
НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2024.12.11

Булган аймаг

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
1.1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн газрын эрхэм зорилго, алсын харааг байгууллагын “www.bu.mohs.gov.mn” вэб хуудсанд байршуулан, салбарын хэмжээнд зохион байгуулсан үйл ажиллагаа, сургалт сурталчилгаа, видео шторк мэдээ мэдээлэл, зөвлөмж нийт 295 удаа байршуулан ил тод байдлыг ханган ажиллаж байна. Нийт 37054 иргэн хандсан. • Шил ажиллагааны систем shilen.gov.mn-д байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдал 99.4%-тай үнэлэгдсэн. • Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр 728 удаагийн танхимын сургалтад 14300 иргэд, сурталчилгаанд давхардсан 42467 тоогоор иргэнийг хамруулж, 14 төрлийн 12600 санамж, 6 төрлийн 4621 зурагт хуудас, давхардсан тоогоор нийт 16 мянга гаруй зөвлөмж, зурагт хуудас, гарын авлагыг иргэд, олон нийтэд түгээсэн. • ЭМБ-ууд нийгмийн эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүд 61, нэрэмжит сарын аян-11 удаа зохион байгуулж, 42467 иргэнийг хамруулсан. • Эрүүл мэндийн газрын албан ёсны цахим хаяг www.bu.mohs.gov.mn болон “Булган Эрүүл мэндийн газар” нүүр хуудсаар мэдээллийг хүргэн ажиллаж, Эрүүл мэндийн байгууллагууд давхардсан тоогоор 501 мэдээллийг цахим хуудсанд байршуулж, 32694 иргэн хандсан үзүүлэлттэй байна. • “Шүд угаах цаг” зохион байгуулах зөвлөмж бичлэгийг Сайхан Монгол тв-тэй хамтран бэлтгэж цахим сургалтыг ЭМБ-ын дарга, нийгмийн ажилтан, ЕБС-ийн захирал, нийгмийн ажилтан, эмч нарт зохион байгуулсан. • “Булган аймаг: Сурагчид ангидаа шүдээ угаах цагтай боллоо” сэдвээр улсын хэмжээний 23 веб сайт, телевизүүдтэй хамтран мэдээллийг олон нийтэд түгээсэн. • “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” арга хэмжээг орон нутагт амжилттай зохион байгуулан 0-17 насны 16872 хүүхэд буюу нийт хамрагдвал зохих хүүхдийн 77.2 хувийг үзлэгт хамруулж, өвчлөл илэрсэн хүүхдүүдийн 85.0 хувийг эмчилгээнд хамруулан, 40%-ийг нь бүрэн эмчилсэн. • Аймгийн хэмжээнд эрт илрүүлэг үзлэгийн хамралт 44.3 хувьтай байгаа нь улсын дунджаас 1.5 хувиар дээгүүр үзүүлэлттэй байна. 	100
1.2.	Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон	<ul style="list-style-type: none"> • Аймгийн Засаг даргын 2023 оны А/638 дүгээр захирамжаар шинэчлэгдэн батлагдсан байгууллагын чиг үүрэг, бүтэц 	100

	нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;	<p>зохион байгуулалт болон хаяг байршил, утасны дугаарыг bu.mohs.gov.mn вэб сайтад ил тод байршуулсан.</p> <ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээ, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагын талаарх иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах 7034-2455 дугаарын утсыг ажлын өдрүүдэд ажиллуулж, байгууллагын вэб сайт болон цахим хуудсанд ил тод мэдээлсэн. • Иргэдээс ирүүлэх өргөдөл гомдлыг хүлээн авах журам, цагийн хуваарийг байгууллагын архив, бичиг хэргийн ажилтны өрөөний хаалга болон цахим хуудсанд байршуулсан. • Салбарын болон байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн сул ажлын байрны байртай холбоотой мэдээ, мэдээллийг Булган Эрүүл мэндийн газар цахим хуудас, bu.mohs.gov.mn вэб хаягаар ил тод нээлттэй мэдээлж байна. 	
1.3.	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;	<ul style="list-style-type: none"> • Улсын төсвийн 1, гүйцэтгэлийн санхүүжилттэй 19, нийт 20 Эрүүл мэндийн байгууллагын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмж, хяналт шалгалтын тайланг gap.mof.gov.mn цахим хаяг болон тухайн байгууллагын “Ил тод байдлын самбар”-т тайлан, дүгнэлтийн хамт ил тод байршуулсан. 	100
1.4.	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;	Эрүүл мэндийн салбарын харилцааг зохицуулж буй хуулин дахь чиг үүргээ хэрэгжүүлэн, ялангуяа цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан хэрэгжилтийг холбогдох дээд шатны байгууллагад хугацаанд нь тайлагнасан.	100
1.5.	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;	<ul style="list-style-type: none"> • Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг үндэсний болон орон нутгийн түвшний бодлогын баримт бичгүүдэд дэвшүүлсэн зорилго, зорилтуудтай уялдуулан, эрүүл мэндийн чиглэлээр 8 зорилтын 21 арга хэмжээг хэрэгжүүлсэн. • “Аймгийн эрүүл мэндийн салбарын стратеги төлөвлөгөө”-нд алсын хараа, эрхэм зорилго, стратегийн зорилгыг тодорхойлон 12 зорилтыг хэрэгжүүлэхээр тусгаж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. • Аймгийн ИТХ-ын 2021 оны IV/03 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэнд” хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж, иргэдийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх олон талт үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж, салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлсэн. • “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуулинд тусгагдсан холбогдох баримт бичгийн хэрэгжилтийн тайланг гаргаж, холбогдох дээд шатны байгууллагад хугацаанд хүргүүлсэн. 	100

1.6.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;	<ul style="list-style-type: none"> • Дээд шатны байгууллагуудаас гаргасан 25 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 70 заалтыг хяналтад авч, хэрэгжилтийг ханган ажиллах талаар удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллан, биелэлтийг холбогдох байгууллагад хугацаанд нь тайлагнасан. 	100
1.7.	Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн газрын төрийн албан хаагчдын утасны дугаар, албаны цахим хаяг болон гамшгийн үед төрийн албан хаагчдыг шуурхай зарлан дуудах схемийг байгууллагын “Ил тод байдлын самбар”-т байршуулсан. • Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 191 дүгээр тогтоолоор батлагдсан төрийн захиргааны албан хаагчдын холбогдох мэдээллийг “bu.mohs.gov.mn” вэб хуудсанд нийтэлсэн. 	100
1.8.	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;	<ul style="list-style-type: none"> • 2024 оны эхний 12 сарын 11-ны байдлаар иргэдээс 202, байгууллагын албан хаагчдаас 30 нийт 232 өргөдөл ирснийг хүлээн авч бүртгэн, хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан. • Нийт 232 өргөдөл хүлээн авснаас 3 өргөдөл хугацаа болоогүй, өргөдөлг гомдлын шийдвэрлэлт 98.7% хувьтай байна. Нийт өргөдлийн <ul style="list-style-type: none"> - Албан бичиг болон цаасаар-229 - Байгууллагын утсаар-3 ирсэн байна. <p>Үүнээс:</p> <p>Санал, гомдол - 10 /4.3%/</p> <p>Хүсэлт –222 /95.7%/</p> <ul style="list-style-type: none"> • Нийт 232 өргөдлийг агуулгаар нь ангилбал: <ul style="list-style-type: none"> - Гэрчилгээ авах хүсэлт ирүүлсэн 3 /1,3%/ - Ажилд орох хүсэлт 23 /9,9%/ - Суралцах хүсэлт ирүүлсэн 9 /3,9%/ - Тэтгэмж хүссэн тухай хүсэлт 143 /61,6%/ - Бусад-44 /хүсэлт гаргах, материал хүргүүлэх 18,9%/ - Гомдол гаргасан 10 /4,4%/ /утсаар-3, бичгээр-7/ өргөдөл хүлээн авсан байна. • Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн, улирал бүр мэдээг гарган аймгийн ЗДТГ-ын ХМОНХА-нд хүргүүлэн ажилласан. 	100
1.9.	Хуульд өөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн салбарын статистик мэдээллийн үйл ажиллагаанд Монгол Улсын “Статистикийн тухай” хууль, “Эрүүл мэндийн тухай” хууль, ЭМС-ын 2019 оны А/611 дугаар тушаалыг баримтлан ажиллаж, аймгийн хэмжээнд нийт 24 хүний нөөцтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Статистикч эмч нарыг чадавхжуулах 1 удаагийн сургалтад хамруулж, 10 Эрүүл мэндийн байгууллагад дэмжлэгт хяналт хийж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажилласан. • Сар тутам эрүүл мэндийн 20 гаруй нэр төрлийн үзүүлэлтийг нэгтгэж боловсруулж, шийдвэр гаргагч, бодлого боловсруулагч, хэрэглэгчдийг мэдээллээр ханган ил тод байршуулан ажиллаж байна. 	100
1.10.	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.	<ul style="list-style-type: none"> • Аймгийн ИТХ-ын 2021 оны IV/03 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэнд ” хөтөлбөрт эрүүл мэндийн салбарын 	100

		<p>тулгамдаж буй асуудал болох нялхсын эндэгдэл, сэргийлж болох өвчлөл, эндэгдэл, нас баралтын түвшнийг бууруулах, халдварт бус өвчний эрт илрүүлгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, салбарын хүний нөөцийг хөгжүүлэх 5 зорилтын 30 арга хэмжээг, 27 шалгуур үзүүлэлтийг хүрээнд ханган ажилласан. Хөтөлбөрийн хэрэгжилт 90,0 %-тай байна.</p> <ul style="list-style-type: none"> Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийг төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүдтэй хамтран зохион байгуулж, нийт хүн амын 44,3 %-ийг хамруулан энэ онд шинээр 162 хорт хавдрын сэжигтэй тохиолдлыг дээд шатлалын эмнэлэгт илгээж, өвчлөлийн 48.1% буюу 78 тохиолдлыг I,II үе шатанд нь оношийг баталгаажуулсан. Халдвар бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн хамралт өмнө оныхоос 2,8 %-иар, хорт хавдар өвчний эрт илрүүлэлт өмнөх оноос 22,9 %-иар нэмэгдэж, сүүлийн 3 жилд хорт хавдар өвчний эрт илрүүлэлт 52,9% болсон байна. Хорт хавдар өвчний 41.9 %-ийг эрчүүдийн өвчлөл эзэлж байна. Өсвөр үеийн хүүхэд, багачуудын амны хөндийн өвчлөлийг эмчлэн, эдгэрүүлэх ажлын хүрээнд ЭМЯ, аймгийн ЗДТГ-ын НБХ-тэй хамтран 6 сумын ЭМТ-ийг шүдний кабинеттай болгож, боловсон хүчнээр ханган, 90 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэн, 0-17 насны хүүхдүүдийн 77,2 хувийг амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулсан байна. 	
Хэсгийн дундаж хувь:100			
Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
2.1.	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;	<ul style="list-style-type: none"> Эрүүл мэндийн байгууллагуудаас 56 ажлын байрны сул орон тоо, дутагдалтай орон тооны зарыг авч, нэгтгэн байгууллагын цахим хуудас, Эрүүл мэндийн ажилтны цахим мэдээллийн hr.hdc.gov.mn-д байршуулсан. Булган аймгийн харьяат оюутнуудтай хийсэн уулзалтад салбарын хэмжээнд дутагдалтай орон тооны талаар мэдээлэл хийсэн. Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтныг сонгон шалгаруулахаар 10 Эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалын сул орон тооны захиалгыг ТАЗ-ийн "Булган аймаг дахь салбар зөвлөл"-д хүргүүлж, нээлттэй сонгон шалгаруулалтаар 6 албан хаагч удирдах албан тушаалд томилогдсон. ХАСХОМ 28, ХАСУМ-8 мэдүүлгийн бүрдүүлэлтийг тухай бүр хуулийн хугацаанд нь мэдүүлсэн. 	100
2.2.	Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;	<ul style="list-style-type: none"> Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 19 Эрүүл мэндийн байгууллага ажилтныг сонгон шалгаруулах журмыг шинэчлэн баталж, шинээр томилогдож байгаа албан хаагчдыг журмын 	100

		<p>дагуу “Нээлттэй сонгон шалгаруулалт”-аар томилж хэвшүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> • Журмыг баримтлан 19 Эрүүл мэндийн байгууллага ажлын байрны сул орон тооны мэдээллийг нийгмийн сүлжээний хаягуудаар нийтэд мэдээллэн, 42 ажлын байр хүний нөөцөөр хангагдсан байна. 	
2.3.	Албан хаагч, ажилтаны ёс зүйн дүрэм;	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчид Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ЭМС-ын 2019 оны А/406 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”-ийг баримтлан ажил үүргээ гүйцэтгэж байна. Ёс зүйн дүрмийг байгууллагын цахим хуудаст нээлттэй байршуулсан. • Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн зөвлөх эмч Анагаах ухааны доктор, профессор Т.Ганцэцэг, сургалтын мэргэжилтэн Э.Мягмарцэрэн нартай хамтран “Эрүүл мэндийн ажилтын сэтгэл зүй”, АШУҮИС-ийн Эрдмийн сургуулийн Анагаах ухааны эрх зүй, боловсрол судлалын тэнхимийн багш, хуульч өмгөөлөгч Э.Ганбаттай хамтран “Мэргэжлийн ёс зүй, харилцаа хандлага”, “Амьдралд суурилж, суралцахуй” ТББ, АШУҮИС-ийн багш Анагаах ухааны доктор, профессор С.Наранчимэг, Сувилахуйн ухааны докторант С.Нармандах нартай хамтран “Мэргэжлийн ёс зүй, харилцааны ур чадвар” сургалтуудыг зохион байгуулсан. Сургалтад 300 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж, хууль эрх зүй, ёс зүйн чиглэлээр зохих мэдлэг, мэдээлэлтэй болсон. 	100
2.4.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;	<ul style="list-style-type: none"> • Салбарын хэмжээнд “Эрүүл мэнд” хөтөлбөр, “Эрүүл мэндийн салбарын стратеги төлөвлөгөө”-нд хүний нөөцийг хөгжүүлэх зорилтыг тусган хэрэгжилтийг 80%-тай ханган ажиллаж байна. • Хөтөлбөр, стратегийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг bu.mohs.gov.mn вэб цахим хуудсанд ил тод байршуулсан. 	100
2.5.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;	<ul style="list-style-type: none"> • 2024-2025 оны хичээлийн жилд төрийн санхүүжилтээр үндсэн болон төрөлжсөн мэргэшил олгох болон мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдах захиалгыг бүх шатны Эрүүл мэндийн байгууллагуудаас албан бичгээр авч, захиалгыг Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлсэн. • Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/162 дугаар тушаалаар батлагдсан сургалтын чиглэл, хяналтын тоог нийт ЭМБ-уудад албан бичгээр 3 удаа, ЭМБ-уудын удирдлагуудаас 7 удаа санал авч, хүний нөөцийн ил тод байдлыг ханган сургалтад 35 албан хаагчдыг суралцуулсан. 	100
2.6.	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.	“Эрүүл мэндийн тухай” хуулийн 30 дугаар зүйлийн 30.5 дэх заалт, “Төрийн албаны тухай” хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Засгийн газрын 2019 оны 395 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоол /“Төрийн жинхэнэ	100

		албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"/, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100, 2023 оны 98 дугаар тушаал, Эрүүл мэндийн Сайдын 2020 оны А/351 дугаар тушаал зэргийг үндэслэн Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнлэх журам"-ыг ЭМГ-ын даргын 2023 оны А/40 дүгээр тушаалаар батлан хэрэгжүүлэн ажиллаж байна. Журмыг байгууллагын сайтад ил тод байршуулсан.	
Хэсгийн дундаж хувь:100			
Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх			
3.1.	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;	Нийт эрүүл мэндийн байгууллагууд 2023 оны жилийн эцэс, 2024 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, 2024 оны батлагдсан төсөв, түүнд орсон өөрчлөлт, 2025-2027 оны дунд хугацааны төсвийн төлөвлөлт зэрэг нийт 88 удаагийн мэдээллийг байгууллагын ил тод байдлын самбар болон info.shilendans.gov.mn цахим сайтад ил тод нийтэд мэдээлсэн.	100
3.2.	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;	2023 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлан, 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг 20 эрүүл мэндийн байгууллага тус бүр 2 удаа буюу 40 мэдээ, тайланг тухайн байгууллагын ил тод байдлын самбар болон info.shilendans.gov.mn цахим сайтад олон нийтэд ил тод мэдээлсэн.	100
3.3.	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;	ЭМБ-ууд 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар аймгийн Аудитын байгууллагаас ЭМГ-1, НЭ-1, Сумын ЭМТ-д-16 нийт 18 байгууллага “Өөрчлөлтгүй”, Өрхийн ЭМТ-2 “Татгалзсан” санал дүгнэлт авсан бөгөөд байгууллагын ил тод байдлын самбар болон info.shilendans.gov.mn цахим сайтад хуулийн хугацаанд олон нийтэд нээлттэй байршуулсан.	100
3.4.	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;	“Халдваргүйтгэлийн норм үнэлгээ шинэчлэн батлах тухай” ЭМГ-ийн даргын А/64 тоот тушаалыг info.shilendans.gov.mn цахим сайтад хуулийн хугацаанд ил тод нээлттэй байршуулсан.	100
3.5.	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;	Тайлант хугацаанд Эрүүл мэндийн байгууллагууд тухайн сарын төсвийн хэмнэлт, хэтрэлтийн шалтгаан, тайлбарыг дараа сарын 8-ны дотор санхүү төрийн сангийн хэлтсийн холбогдох мэргэжилтнээр хянан баталгаажуулж хуулийн хугацаанд нийт 11 удаагийн 220 мэдээллийг info.shilendans.gov.mn цахим хаяг болон байгууллагын ил тод байдлын самбарт нийтэд ил тод байршуулсан байршуулсан.	100
3.6.	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;	Халаалт, дулаан, түлш шатахуун, эм, хоол хүнс, нормын хувцас, багаж хэрэгсэл гэх мэт 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий бараа, ажил үйлчилгээ нийлүүлсэн ханган нийлүүлэгч 788 /давхардсан тоогоор/ байгууллагуудын мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн	100
3.7.	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн	Эрүүл мэндийн байгууллагуудын цалингийн зардлаас бусад эм, хоол, шатахуун, халаалт, багаж тоног төхөөрмж, нормын хувцас, болон	100

	гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;	бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зэрэг 5,0 сая төгрөгөөс дээших зарлагын 524, орлогын 531, нийт 1055 мэдээллийг shilendans.gov.mn сайтад гүйлгээ тус бүрээр хүлээн авагч байгууллагын нэрээр нийтэд ил тод хуулийн хугацаанд мэдээлсэн.	
3.8.	Бонд, зээл өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр;	Төсвийн шууд захирагчийн эрх үүргийн дагуу гаргасан хөрөнгө худалдан авах, тэтгэмж, урамшуулал олгох зэрэг төсөв, хөрөнгө, мөнгө зарцуулах 242 удаагийн шийдвэрийг info.shilendans.gov.mn цахим сайтад хуулийн хугацаанд байршуулсан	100
3.9.	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;	2024 оны эхний 11 сарын байдлаар салбарын хэмжээгээр info.shilendans.gov.mn цахим сайтад нийт 2942 мэдээ мэдээллийг байршуулснаас 2899 мэдээллийг хуулийн хугацаанд нь, 43 мэдээллийг хугацаа хоцроож, шилэн дансны хэрэгжилт 98.5 хувьтай байна. Байгууллагын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд өгсөн аудитын зөвлөмжийг 100% хэрэгжүүлэн, хэрэгжилтийн тайланг аймгийн Аудитын байгууллага болон ЭМЯ-ны СДХ-т хугацаанд нь хүргүүлсэн.	90
3.10.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендер оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендер шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр эм, эмнэлгийн хэрэгслийн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер худалдан авах ажиллагаа хийгдээгүй болно.	100
3.11.	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт;	Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнэлтийг жилд нэг буюу мэдээлэл, худалдан авах ажиллагаанд хийгдсэн аудитын тайлан болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагаас ирүүлсэн шалгалтын тайлан, дүгнэлтийг сар бүр хуулийн хугацаанд иргэдэд ил тод нээлттэй мэдээлсэн.	100
3.12.	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;	Эрүүл мэндийн салбарын хэмжээнд нийт 12 албан хаагч худалдан авах ажиллагааны мэргэшсэн АЗ сертификат авсан.	100
3.13.	Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;	“Азийн хөгжлийн банк”-ны төслөөр хэрэгжүүлж байгаа Дашинчилэн сумын 15 ортой Эрүүл мэндийн төвийн барилгын ажлын гүйцэтгэгчээр “Цомбон тоосго” ХХК шалгарч, 2024 оны барилгын ажил 60%-ийн гүйцэтгэлтэй явагдсан. Орон нутгийн төсвийн 602.0 сая төгрөгийн санхүүжилтаар тендер зарлаж шалгарсан “Бурхуд” ХХК нь тус ЭМТ-ийн барилгын /дулаан хангамж, цахилгаан хангамж, цэвэр ус, бохир/-ын дэд бүтцийн ажлыг 100% хийж гүйцэтгэж, хүлээлгэн өгсөн. Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар 2 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн	100

		64,4 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан. Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр 255 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадахжуулж, 1-12 дугаар ангийн 529 хүүхдийн өвчлөлийг илрүүлж, эмчлэн эрүүлжүүлэх ажил үргэлжилж байна. Хийсэн ажлын тайлан мэдээг тухай бүр нь цахим хуудас болон шилэн дансанд байршуулсан.	
3.14.	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан;	Байхгүй.	100
3.15.	Хууль тогтоомжид заасан бусад.	Төсвийн болон Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомжоор олгосон чиг үүргийг хэрэгжүүлэн, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.	100
Хэсгийн дундаж хувь:99,3			
Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн талаарх			
4.1.	Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;	Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах мөн ариутгал, халдваргүйтгэлийн үйлчилгээ үзүүлэх журам, үйл ажиллагааг байгууллагын цахим хуудаст байршуулсан.	100
4.2.	Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын хурлыг 9 удаа зохион байгуулж, шинээр эмийн сан байгуулах 5 аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээн авч, шинжээч ажиллуулан шаардлага хангасан 2 эмийн сан, 1 уламжлалт анагаахын бариа засал эмчилгээ 1, хяналт-клиник буюу амбулатори, өдрийн эмчилгээ 1, рашаан сувилал 1 нийт 4 байгууллагад 3 жилийн хугацаатай тусгай зөвшөөрөл олгосон. • Тусгай зөвшөөрөл сунгах хүсэлт өгсөн 34 байгууллагын ирүүлсэн материал болон ажлын байранд үнэлгээ, дүгнэлт хийн холбогдох хууль, журмыг баримтлан 5 жилийн хугацаатай сунгасан. Тусгай зөвшөөрлийн аж ахуйн нэгжийн нэр өөрчлөх хүсэлт өгсөн 2 байгууллагын хүсэлтийг шийдвэрлэсэн. • Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан, ажиллахгүй байгаа 8 байгууллагын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож шийдвэрлэсэн. • Тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийг тухай бүр байгууллагын цахим хуудаст байршуулан ажиллаж байна. 	100
Хэсгийн дундаж хувь: 100,0			
Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
5.1.	Олон нийтийн хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал;	ЭМЯ болон аймгийн ЗДТГ-аас цаасаар болон цахимаар авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөлд тухай бүрд нь санал хүргүүлж ажилласан.	100
5.2.	Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт;	Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт байхгүй болно.	100
5.3.	Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл;	Аймгийн Эрүүл мэндийн салбартай холбоотой аймаг, сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах санал тусгагдаагүй болно.	100
5.4.	Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл;	Эрүүл мэндийн газрын Булган сумын 6-р багийн Чин Ван Ханддоржийн өргөн чөлөө-1,	100

		103-т байрлах 6308003519 нэгж талбарын 1648 м/кв га газрын Э-0405000594 тоот улсын бүртгэлтэй газар эзэмших эрхийн гэрчилгээг сайт болон мэдээллийн самбарт ил тод байршуулсан.	
5.5.	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг;	Төрийн өмчит Эрүүл мэндийн байгууллагууд 2024 оны эхний 11 сарын байдлаар ХХОАТ-1221,8 сая, тээврийн хэрэгслийн татварт 1,6 сая нийт 1223,4 сая төгрөгийн татварыг улсын төсөвт төвлөрүүлээд байна.	100
5.6.	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл;	Хамааралгүй.	100
5.7.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл;	Аймгийн ИТХ-ын 2024 оны ээлжит XX дугаар хуралдааны 03, XXIV хуралдааны 06, XXV хуралдааны 06, XXV хуралдааны 10 дугаар тогтоолоор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 3, Рашаант сумын ЭМТ-ийн 1, Могод сумын ЭМТ-ийн 1, Хутаг-Өндөр сумын ЭМТ-ийн 1, нийт 6 автомашин тус тус нээлттэй дуудлага худалдаагаар худалдан борлуулах шийдвэр гарч биелэлтийг холбогдох байгууллагад хүргүүлсэн.	100
5.8.	Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Рентген оношилгооны өрөө нь MNS 5391: 2010 стандартын шаардлагыг хангадаггүй. Үүнтэй холбоотой барилгын засварын санхүүжилтийн саналыг аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн. Тус эмнэлгийн рентгений өрөөний барилгын зураг, төсвийг боловсруулан ажиллаж байна.	100
5.9.	Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт;	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн зам талбайн засвар, Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн барилгын гаднах засвар, Дашинчилэн сумын ЭМТ-ийн шинэ барилгын дэд бүтцийн /цахилгаан, халаалт, цэвэр, бохир/-ын ажил, Бугат сумын ЭМТ-ийн барилгын засварын ажлууд хийгдэж, улсын комисс ажиллаж бүрэн ашиглалтанд хүлээн авсан.	100
5.10.	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай	Хамааралгүй.	100

	зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ;		
5.11.	Нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл;	Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь Төрийн үйлчилгээний нэгдсэн систем https://e-mongolia.mn/ -ээр дамжуулан үзлэгийн цаг захиалах, шинжилгээний хариу авах, хөнгөлөлттэй болон энгийн эмийн жорын мэдээллийг цахимаар авах үйлчилгээг үзүүлж байна.	100
5.12.	Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/ -ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт;	Тайлант онд Аймгийн Нэгдсэн эмнэлгийн АЗ-худалдан авах ажиллагааны сургалтанд-3 хүн, МЦАЦ-ын нийгэмлэг-2 хүн, ёс зүйн сургалтанд-30 бүгд 35 эмч эмнэлгийн ажилтан хамруулсан. Сургалтын төлбөр нийт 915,000 төгрөгийг аймгийн Нэгдсэн эмнэлгээс зарцуулсан. ЭМГ-ын бичиг хэргийн ажилтаны мэргэжил олгох сургалтанд 1 мэргэжилтэнд 150,000 төгрөгийг байгууллагаас төлсөн байна. Сайхан сумын ЭМТ Глобал сургуулийн Сувилагчийн сургуульд суралцаж буй оюутны төлбөр болох 1.140.000 төгрөгийг байгууллагаас төлсөн байна.	100
5.13.	Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл.	“Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн 8.6-д заасны дагуу нээлттэй байх мэдээллүүдийг байгууллагын сайт болон мэдээллийн самбарт ил тод байршуулан ажиллаж байна.	100
Хэсгийн дундаж хувь:100			
Хэрэгжилтийн дундаж хувь: 99.8%			